



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/148/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn.
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	9
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Эзб сафт: dornogovi@audit.gov.mn

2020.01.28 № 1-6/248

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунцэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2020 оны 1 дүгээр сарын 29-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны зорилго нь багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргахад оршино.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт өөрчлөлт гараагүй байна

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 301,880,53 мянган төгрөгөөс тооцон 603.60 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 603.60 мянган төгрөгөөр тооцсон нь батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг материаллаг байдлын сууриар сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,442.10 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2091.0	3906.9	1815.8
Урьдчилгаа			

Бараа материал	37108.3	35526.8	-1581.6
Үндсэн хөрөнгө	528326.4	505650.0	-22676.4
Нийт хөрөнгө	567525.8	545083.8	-22442.1
Өр төлбөр	222.2	0	-222.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	567303.6	545083.8	-22219.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	567525.8	545083.8	-22442.1

Авлага дансны үлдэгдэл өссөн нь эрхлэгчээр ажиллаж байсан А.Мөнхчимэг нь 3,090,0 мянган төгрөгийн нүүрс, 639,1 мянган төгрөгийн дээжний хөргөгч дутагдуулснаас авлага нэмэгдсэн, удаан жил болсон 1,913,2 мянган төгрөгийн авлагыг барагдууланаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь энэ онд төсвийн хөрөнгөөр 3,000,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй 144,0 мянган төгрөгийн ном авч нийт 3,144,0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 639,1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж дутагдсаныг данснаас хасч авлага үүсгэсэн мөн тайлант онд 25,415,6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 222,2 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 543,083.8 мянган төгрөг болж 22,219.8 мянган төгрөгөөр буурсан нь дээр дурдсан шалтгаанууд тайлант хугацааны үр дүнд нөлөөлснөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1,913.2 мянган төгрөгийн бичилт нь эзэн холбогдолгүй удаан жил болсон авлагыг хаасантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 278,005.60 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардлын 254,768.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,337.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 277,609.98 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтэлийн зардал 386.5 мянган төгрөгөөр хэмнэсэн шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болон нэмэлт санхүүжилт байхгүй.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,906.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,906.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 3,906.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах, анхаарал татахуйц асуудал гараагүй болно

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс 2019 оны жилийн эцсийн байдлаар зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2019 оны 3 дугаар сар хүртэл ажиллаж байсан эрхлэгч А.Мөнхчимэгт холбогдох 3,090.00 мянган төгрөгийн нүүрс, 639.10 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нярваар ажиллаж байсан С.Болортуяад холбогдох дутагдал буюу 177,84 мянган төгрөгийн тус тус авлагатай байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.1.1 Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2019 оны 3 дугаар сар хүртэл ажиллаж байсан эрхлэгч А.Мөнхчимэгт холбогдох 3,090.00 мянган төгрөгийн нүүрс, 639.10 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нярваар ажиллаж байсан С.Болортуяад холбогдох дутагдал буюу 177,84 мянган төгрөгийн тус тус авлагатай байна

Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5.1.5, 6.4.8 заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1 заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх, авлага, өглөг барагдуулаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5.1.5, 6.4.8 заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1 заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах, харьяалагдах Шүүхийн байгууллагад авлагатай холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, хөөн хэлэлцэх хугацаанд багтаан нэхэмжлэл гаргах нь зүйтэй байна.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,199,440.80	39,433,727.80
27	АВЛАГА	2,091,068.00	3,906,940.00
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,913,228.00	-
34	Бусад авлага	177,840.00	3,906,940.00
36	Хувь хүмүүсээс авах авлага	177,840.00	3,906,940.00
60	БАРАА МАТЕРИАЛ	37,108,372.80	35,526,787.80
61	Түүхий эд материал	1,853,185.86	1,843,385.86
62	Тусгай зориулалттай материал	1,742,885.86	1,742,885.86
63	Эм боох материал	110,300.00	100,500.00
66	Хангамжийн материал	35,255,186.94	33,683,401.94
67	Бичиг хэргийн материал	1,220,880.00	991,360.00
68	Аж ахуйн материал	20,462,566.73	19,442,416.73
70	Түлш шатах тослох материал	4,832,150.00	4,998,900.00
72	Хүнсний материал	2,377,540.00	1,888,675.00
73	Бусад хангамжийн материал	6,362,050.21	6,362,050.21
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	528,326,419.17	505,650,051.25
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	528,326,419.17	505,650,051.25
108	Биет хөрөнгө	518,754,419.17	496,078,051.25
109	Барилга, байгууламж	430,253,558.25	430,253,558.25
110	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,633,823.52)
111	Авто тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(13,079,166.91)	(15,229,166.95)
113	Машин, тоног төхөөрөмж	37,362,490.00	39,723,390.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(16,551,834.83)	(20,919,411.85)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,024,985.33	52,024,985.33
116	Хуримтлагдсан элэгдэл	(28,644,939.06)	(32,628,101.16)
122	Бусад үндсэн хөрөнгө	38,178,683.00	38,178,683.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(4,081,414.29)	(11,128,119.53)
125	Номын фонд	1,792,057.68	1,936,057.68
126	Биет бус хөрөнгө	9,572,000.00	9,572,000.00
127	Програм хангамж	250,000.00	250,000.00
128	Хасагдуулга	(250,000.00)	(250,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	9,572,000.00	9,572,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	567,525,859.97	545,083,779.05
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	222,258.00	-
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	222,258.00	-
164	Өглөг	222,258.00	-
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	222,258.00	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	567,303,601.97	545,083,779.05
215	Засгийн газрын хувь оролцоо	567,303,601.97	545,083,779.05
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	62,480,436.08	62,480,436.08
217	Өмч: -Төрийн өмч	62,480,436.08	62,480,436.08
223	Хуримтлагдсан үр дүн	503,811,483.54	481,591,660.62
224	Өмнөх үеийн үр дүн	503,811,483.54	501,898,255.54
225	Тайлант үеийн үр дүн	-	(20,306,594.92)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,011,682.35	1,011,682.35
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	567,525,859.97	545,083,779.05

4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	302,926,200.00	278,249,600.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,163,200.00	144,000.00
77	Нийтлэг татварын бус орлого	47,163,200.00	144,000.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	47,163,200.00	144,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,163,200.00	144,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,000,000.00	23,337,600.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	249,763,000.00	254,768,000.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	6,000,000.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	23,337,600.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	23,337,600.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	261,610,332.93	301,880,531.66
148	УРСГАЛ ЗАРДАЛ	261,610,332.93	301,880,531.66
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,718,005.43	301,384,916.87
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	150,972,077.70	188,651,204.00
151	Цалин	150,972,077.70	188,651,204.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,547,980.00	24,008,453.21
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,387,275.00	16,325,735.21
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,488,825.00	1,689,158.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,283,490.00	1,768,064.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	308,038.00	384,138.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,080,352.00	3,841,358.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,284,455.00	19,554,250.00
165	Гэрэл цахилгааны зардал	2,210,205.00	3,420,000.00
166	Түлш, халаалтын зардал	11,434,250.00	14,542,250.00
167	Цэвэр, бохир усны зардал	640,000.00	1,592,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	9,674,162.00	5,644,430.00
171	Бичиг хэргийн материал	1,308,480.00	1,251,520.00
172	Тээвэр, шатахууны зардал	2,899,570.00	1,348,680.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	720,000.00	50,000.00
174	Ном, хэвлэлийн зардал	21,660.00	-
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	270,000.00	150,000.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4,454,452.00	2,844,230.00
181	Нормативт зардал	31,450,682.50	34,263,975.00
182	Эм	62,900.00	75,300.00
183	Хоол	31,387,782.50	34,188,675.00
190	Томилолт, зочны зардал	416,700.00	334,000.00
192	Дотоод томилолтын зардал	416,700.00	334,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	242,500.00	423,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	242,500.00	263,000.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	160,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	22,129,448.23	28,505,604.66
210	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,090,000.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	22,000.00	-
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,107,448.23	25,415,604.66
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,892,327.50	495,614.79

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

228	Бусад урсгал шилжүүлэг	13,876,200.00	100,000.00
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,876,200.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	100,000.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,127.50	-
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,127.50	-
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,600.00
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,600.00
247	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	-	394,014.79
250	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	394,014.79
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	41,315,867.07	(23,630,931.66)
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	3,324,336.74
271	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	3,324,336.74
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	135,098,290.73	-
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,944,332.81	-
283	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	130,153,957.92	-
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(135,098,290.73)	3,324,336.74
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(93,782,423.66)	(20,306,594.92)

4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	255,763,000.00	278,105,600.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	255,763,000.00	278,105,600.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	249,763,000.00	254,768,000.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	6,000,000.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	23,337,600.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	23,337,600.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	240,913,000.00	275,105,600.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	240,913,000.00	275,105,600.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	227,020,672.50	274,609,985.21
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	150,532,200.00	188,651,200.00
151	Үндсэн цалин	138,221,200.00	155,996,100.00
152	Нэмэгдэл	4,111,000.00	19,655,100.00
154	Үр дүнгийн урамшуулал	8,200,000.00	13,000,000.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,594,100.00	24,230,715.21
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,775,900.00	18,113,915.21
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,163,700.00	1,165,100.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,454,600.00	1,547,300.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	290,900.00	309,700.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,909,000.00	3,094,700.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	15,018,815.00	23,136,000.00
165	Гэрэл цахилгааны зардал	2,809,205.00	3,420,000.00
166	Түлш, халаалтын зардал	10,715,400.00	17,799,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,494,210.00	1,917,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	7,512,500.00	3,088,140.00
171	Бичиг хэрэг	97,000.00	100,000.00

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

172	Тээвэр, шатахуун	2,045,360.00	1,348,680.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	760,200.00	50,380.00
174	Ном, хэвлэл	189,960.00	190,000.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	150,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,149,980.00	1,249,080.00
181	Нормативт зардал	33,503,157.50	33,776,310.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,200.00	65,500.00
183	Хоол, хүнс	32,864,957.50	33,710,810.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	200,000.00
189	Урсгал засвар	200,000.00	200,000.00
190	Томилолт, зочны зардал	416,700.00	334,000.00
192	Дотоод албан томилолт	416,700.00	334,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,500.00	423,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	242,500.00	263,000.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	160,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,700.00	770,620.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,700.00	770,620.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,892,327.50	495,614.79
225	Бусад урсгал шилжүүлэг	13,876,200.00	100,000.00
232	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,876,200.00	-
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	100,000.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,127.50	-
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,127.50	-
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,600.00
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,600.00
244	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	394,014.79
247	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	394,014.79
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,850,000.00	3,000,000.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,850,000.00	3,000,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,850,000.00	3,000,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	14,850,000.00	3,000,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,850,000.00	3,000,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(14,850,000.00)	(3,000,000.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	597,593,907.20	661,086,025.63
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	597,593,907.20	661,086,025.63
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(93,782,423.66)	(93,782,423.66)
9	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	503,811,483.54	567,303,601.97
10	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	503,811,483.54	567,303,601.97
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,913,228.00)	(1,913,228.00)
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	501,898,255.54	565,390,373.97
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(20,306,594.92)	(20,306,594.92)
18	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	481,591,660.62	545,083,779.05

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	278,105,600.00	277,709,985.21	395,614.79	99.86
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	278,105,600.00	277,709,985.21	395,614.79	99.86
4	Бараа, үйлчилгээний зардал	278,005,600.00	277,609,985.21	395,614.79	99.86
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,651,200.00	188,651,200.00	-	100.00
6	Үндсэн цалин	155,996,100.00	155,996,100.00	-	100.00
7	Нэмэгдэл	19,655,100.00	19,655,100.00	-	100.00
9	Урамшуулал	13,000,000.00	13,000,000.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,617,200.00	24,230,715.21	386,484.79	98.43
12	Тэтгэврийн даатгал	18,206,300.00	18,113,915.21	92,384.79	99.49
13	Тэтгэмжийн даатгал	1,282,200.00	1,165,100.00	117,100.00	90.87
14	ҮОМШӨ ний даатгал	1,602,700.00	1,547,300.00	55,400.00	96.54
15	Ажилгүйдлийн даатгал	320,500.00	309,700.00	10,800.00	96.63
16	Эрүүл мэндийн даатгал	3,205,500.00	3,094,700.00	110,800.00	96.54
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,137,600.00	23,136,000.00	1,600.00	99.99
18	Гэрэл цахилгаан	3,420,000.00	3,420,000.00	-	100.00
19	Түлш, халаалт	17,800,000.00	17,799,000.00	1,000.00	99.99
20	Цэвэр, бохир ус	1,917,600.00	1,917,000.00	600.00	99.97
22	Хангамж, бараа материалын зардал	3,093,880.00	3,088,140.00	5,740.00	99.81
23	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	1,348,680.00	1,348,680.00	-	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	55,200.00	50,380.00	4,820.00	91.27
26	Ном, хэвлэл	190,000.00	190,000.00	-	100.00
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	150,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,250,000.00	1,249,080.00	920.00	99.93
30	Нормативт зардал	33,778,100.00	33,776,310.00	1,790.00	99.99
31	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,500.00	65,500.00	-	100.00
32	Хоол, хүнс	33,712,600.00	33,710,810.00	1,790.00	99.99
34	Эд хогшил худалдан авах	3,200,000.00	3,200,000.00	-	100.00
35	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
38	Урсгал засвар	200,000.00	200,000.00	-	100.00
39	Томилолт, зочны зардал	334,000.00	334,000.00	-	100.00
41	Дотоод албан томилолт	334,000.00	334,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	423,000.00	423,000.00	-	100.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	263,000.00	263,000.00	-	100.00
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	160,000.00	160,000.00	-	100.00

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

53	Бараа үйлчилгээний бусад зардал	770,620.00	770,620.00	-	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	770,620.00	770,620.00	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	100,000.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	100,000.00	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	100,000.00	100,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	278,105,600.00	278,105,600.00	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	254,768,000.00	254,768,000.00	-	100.00
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	254,768,000.00	254,768,000.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,337,600.00	23,337,600.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	23,337,600.00	23,337,600.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	17	17	-	100.00
134	Удирдах ажилтан	1	1	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	8	8	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	8	8	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-

4.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,033,378.70	(1,033,378.70)	-
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,033,378.70	(1,033,378.70)	-
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,033,378.70	(1,033,378.70)	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-